

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн XI хуралдаан 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр хуралдаж, 2019 оны төсвийн гүйцэтгэл, 2020 оны төсвийн тодотголын асуудлуудыг хэлэлцэн баталлаа. Тус хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргыг чөлөөлөх саналыг нэмж оруулснаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, “Тайшир-Гуулин усан цахилгаан станц” ХХК-ийн гүйцэтгэх захирал Дүгэрийн Амартүвшин төлөөлөгчдийн олонхын саналаар сонгогдлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга 09 дүгээр сарын 22-23-ны өдөр тус аймагт ажиллаж, иргэдтэй уулзан, улс орны эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдлын талаар тодорхой мэдээлэл өгч, иргэдийн санал хүсэлтийг нь сонсон, тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд санаачилгатай ажиллахаа илэрхийллээ. Тухайлбал: хөдөө аж ахуйн салбар, ялангуяа малын гаралтай түүхий эд үнэгүйдэж байгаа талаар олон удаа санал, хүсэлт тавьж байгааг онцлон тэмдэглэлээ.

Мөн “Тайшир-Гуулин усан цахилгаан станц” ХХК-ийн үйл ажиллагаатай танилцаж, ажиллагсдын санал, хүсэлтийг сонсож, улс орны эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдлын талаар тодорхой мэдээлэл өглөө.

Ерөнхийлөгч аймагт ажиллах хугацаандаа 186 ээжид “Эхийн алдар” одонг гардуулан өглөө.

НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгээр 2020 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр Эрдэнэ сумд “Сайн туршлага хуваалцах” арга хэмжээг зохион байгуулж, аймгийн удирдах ажилтнууд болон 18 сумын 80 гаруй төрийн албан хаагч оролцож, тус сумын төрийн байгууллагуудын үйл ажиллагаагаар танилцан харилцан туршлага, мэдээллээ солилцлоо.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, төрийн байгууллагын үйлчилгээг иргэдэд ойртуулж хүргэх, шинээр гарсан хууль тогтоомжийг сурталчилах, иргэдийн санал, хүсэлтийг сонсох зорилгоор хуулийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөр” арга зохион байгуулж, иргэдийн санал бодлыг судалж, цаашид үйл ажиллагаандаа анхаарах асуудлуудыг тодорхойллоо.

НҮБ-ын Хүүхдийн сан, Пипл Ин нийд ОУБ, Монголын Скаутын холбоо, ШУТИС-ийн ажлын хэсэг тус аймагт ажиллаж, “Говь-Алтай аймгийн цэвэр агаар” хөтөлбөрийг боловсруулах хэлэлцүүлгийг 09 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулж, уг хөтөлбөрийн төслийг боловсрууллаа.

Төрийн албаны салбар зөвлөлөөс төрийн захиргааны удирдах 8, гүйцэтгэх 22 албан тушаалд тусгай шалгалт, 2 албан тушаалд төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтыг тус тус зохион байгуулах сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд албан бичгээр хүргүүллээ.

Төрийн албаны зөвлөлөөс төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн нэгдсэн зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулж, 149 төрийн албан хаагч оролцож, мэдлэгээ дээшлүүллээ.

Удирдлагын академиас зохион байгуулсан төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдын чиглүүлэх зайн сургалтад 9 албан хаагч хамрагдан, суралцаж байна.

Үйлчилгээний нэгдсэн төв нь 162 нэр төрлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд нэг цэгээс шуурхай хүргэж, 6500 иргэнд үйлчилгээ үзүүлээд байна. Тайлант хугацаанд 24 өргөдөл ирсэн бөгөөд 5 өргөдлийг шийдвэрлэж, 19 өргөдлийн хугацаа болоогүй, холбогдох арга хэмжээ авч байна.

“Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111” дүгээрийн утсаар холбогдсон 29 иргэний санал, хүсэлтийг хүлээн авч, 18 өргөдлийг шийдвэрлэж, 11 өргөдлийн хугацаа болоогүй судлагдаж байгаа бөгөөд шийдвэрлэлт 62.0 хувьтай байна.

Аймгийн Үйлчилгээний нэгдсэн төв, сумдын Засаг даргын Тамгын газрын оператор ажилтнуудаар дамжуулан иргэн, хуулийн этгээдэд 26 төрлийн 1980 лавлагааг олгож, 2170.0 мянган төгрөгийг төвлөрүүллээ.

ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг дарга тайлант хугацаанд 52 захирамж гаргаж, шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор захирамжуудыг скайнердаж, аймгийн албан ёсны www.govi-altai.gov.mn сайтад байршууллаа.

Баян-Уул, Бигэр, Дарив, Есөнбулаг, Жаргалан Шарга, Эрдэнэ сумдын Засаг даргын нийт 327 захирамжийг хянаж, үүнээс эрх зүйн үндэслэлийг хангуулаагүй зөрчилтэй 65, албан хэрэг хөтлөлтийн сатндартын зөрчилтэй 75 захирамжийн зөрчлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус аймагт баригдаж байгаа 50 айлын орон сууцны барилга угсралтын ажлын захиалагч, гүйцэтгэгч, захиалагчийн хяналт тавих байгууллагуудын хоорондох гурвалсан гэрээг хянаж, гэрээнд тусгах 14 саналыг дүгнэлтээр хүргүүллээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 16 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг чиглэлийн хүрээнд “Аймгийн нутаг дэвсгэрт шинээр шашины байгууллага байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын төслийг боловсрууллаа.

Иргэд олон нийтийг хуулийн мэдээлэл зөвлөгөөгөөр хангах, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор хуулийн байгууллагуудын “Нээлттэй хаалга”-ны өдрийг 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулж, өдөрлөгт аймгийн Шүүхийн тамгын газар, Прокурорын газар, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээний алба, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Гадаадын иргэн харъяатын газрын баруун бүс дэх газрын аймаг дахь албан хаагчид, Хуульчдын холбооны аймаг дахь салбар, Эрх зүйн туслалцааны төв, Өмгөөлөгчдийн зөвлөл,

оролцож, үйл ажиллагаагаа сурталчилан, иргэдэд хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, архивын лавлагааг 21 иргэнд үнэ төлбөргүй олголоо.

Мөн талбайд байрлах лед дэлгэцээр “Шударга ёсны үнэ цэнэ”, “Авлигын эсрэг олуулаа нэгдье”, “Гэрэл тусгая”, “Арын хаалга”, “Албаны мэдээллээ аминдаа”, “Гайтай бэлэг”, “Танилын гуйлт”, “Авлигын шилэн бөмбөлөг”, “Авлига хожихгүй нүүдэл”, “Төрийн албан хаагч танаа 1”, “Төрийн албан хаагч танаа 2”, “110 дугаарын сурталчилгаа” телевизийн шторкыг цацаж, иргэдэд мэдээлэл хүргэлээ.

Авлигын эсрэг хуулийг сурталчилсан тараах материалыг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах талаар сум, агентлагт үүрэг чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар 2500 гаруй төрийн албан хаагч, 5000 гаруй иргэнд мэдээлэл, сургалт зохион байгуулж, 15000 гаруй боршур, гарын авлагыг тараан, сумдын ЗДТГ-ын мэдээллийн самбар, цахим хуудсаар тус тус хүргэлээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь заалтын дагуу Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын захирал, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн, Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэнд тус тус томилогдохоор нэр дэвшиж буй этгээдүүдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим системд бүртгэж, тухайн албан тушаалд томилогдоход ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэхийг хянуулахаар Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтэст хүргүүлээ.

Архивын тасаг: Архивын баримтаас 177 иргэнд мал тооллогын болон цалин, тушаалын 3250 хуудас лавлагааг олгож, 3020300 төгрөгийг Төрийн сангийн дансанд төвлөрүүлээ. Архивын сан хөмрөгт шинээр ашиглалтад орсон Усан спорт чийрэгжүүлэлтийн төв, Алтай хотын гэр хорооллын явган хүний зам барих ажил, Хөгжил хорооллын 1,2,3,4 дүгээр орон сууц, Алтайн таван богдын орон сууц, хуучин Нийгмийн даатгалын байрны засварын ажил, Төв гудамжны ногоон байгууламж шинэчлэх өргөтгөлийн ажил, Бигэр сумын сургуулийн барилгын ажилтай холбогдох бичиг баримтыг хүлээн авч, нөхөн бүрдүүлэлт хийлээ.

Мөн Есөнбулаг, Баян-Уул, Дарив сумын малын А дансны 43 хадгаламжийн нэгжийн 12764 хуудас баримтыг тусгай программаар сайжруулан засварлалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:Тайлант хугацаанд 583 гүйцэтгэх хуудасны 2645.8 сая төгрөгийн шийдвэр биелүүлэхээс 277 гүйцэтгэх хуудасны 776.1 сая төгрөгийн гүйцэтгэх баримт бичгийг биелүүлж, шийдвэрийн биелэлт 47.5 хувьтай байна.

Хүүхдийн тэтгэлэг төлөгч нийт 147 төлөгчөөс 257.0 сая төгрөгийн тэтгэлэг гаргуулахаас 82 тэтгэлэг төлөгчийн 87.8 сая төгрөгийг хэсэгчлэн биелүүлж, биелэлт 59.3 хувьтай байна.

Хорих ангид ял эдэлж байгаа 10 хоригдолтой холбоотой 57 гүйцэтгэх хуудасны 94.4 сая төгрөгийн хохирол гаргуулахаас 5 хоригдлын 13 гүйцэтгэх хуудасны 10.3 сая төгрөгийн төлбөрийг гаргууллаа.

Улсын бүртгэлийн хэлтэс: Тайлант хугацаанд иргэний бүртгэлийн 422 лавлагааг өгч, 5 иргэний гадаад паспортын захиалга авч, 5 хуулийн этгээдийг шинээр, 34 хуулийн этгээдийг дахин бүртгэж, нийт 39 хуулийн этгээдэд гэрчилгээ олгож, бүртгэлийн цахим мэдээллийн санг тухай бүр баяжуулан ажиллалаа.

Иргэд, хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 339 мэдүүлгийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн, бүртгэлийн үйлчилгээний хураамж 4036676 төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 132969 төгрөг, татварын орлого 10290000 төгрөг, нийт 14459645 төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

Иргэний бүртгэлийн чиглэлээр 53, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 59, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 10, улсын бүртгэлийн архивын чиглэлээр 10, нийт 132 бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, журам зөрчсөн 33 иргэнд 740.0 мянган төгрөгийн шийтгэл ногдууллаа.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Эхний 9 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсөвт 5022.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 5386.7 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 107.3 хувиар, улсын төвлөрсөн төсөвт 904.3 сая төгрөг төвлөрүүлэхээс 865.2 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 95.7 хувиар биелүүллээ.

Улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр 13245.0 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 26347.0 сая төгрөгийг бүрэн авч сум, байгууллагуудын санхүүгийн дэмжлэгийг бүрэн олголоо.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээр 5499.9 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 3641.5 сая төгрөгийн санхүүжилт авч, хуваарилан олгож байна.

Улсын төсвийн тодотголоор тус аймгийн санхүүгийн дэмжлэг 646.7 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 660.3 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлэг 390.7 сая төгрөгөөр тус тус буурсан бөгөөд орон нутгийн төсвийн тодотголыг 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 11 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 1, улсын төсвийн хөрөнгөөр 5, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1, сумын орон нутгийн сангийн хөрөнгөөр 1, гадаадын хөрөнгө оруулалтаар 1, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1, нийт 10 тендерийг зарлалаа.

Гадаадын хөрөнгө оруулалтаар 2, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1, улсын төсвийн хөрөнгөөр 2, нийт 5 тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Хүнхэр зуслангийн 5 байрны засварын ажлын тендерт шууд гэрээ байгуулах эрхийг тус тус олголоо.

Орон нутгийн өмчит нийт 35 байгууллагын хөрөнгөд үнэ тогтоох саналыг хүлээн авч нэгтгэж байна.

ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Тайлант хугацаанд 1772.1 тн өвс, 66.5 тн тэжээл, 55.1 тн гар тэжээл, 891 тн хужир шүү бэлтгээд байна. Аймгийн аюулгүйн нөөц бүрдүүлэхэд дутагдалтай байгаа 230 тн өвс, 100 тн хивгэн тэжээлийг худалдан авахаар нээлттэй тендер зарлаад байна.

Тус аймгийн урд бүсийн сумууд гантай, малын тарга хүч муу, өвөлжилт хүндрэх төлөвтэй байгаатай холбоотой улсын тусгай хамгаалалттай газарт 4 сумын 262 малчин өрхийн 282,6 мянган толгой мал, хилийн зурвас газар 2 сумын 101 өрхийн 69,0 мянган толгой мал, улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутагт отроор 2 сумын 30 өрхийн 32,6 мянган толгой мал өвөлжиж, хаваржих урьдчилсан судалгаа гарсан бөгөөд өөр аймгийн нутагт 8 сумын 59 өрхийн 32.4 мянган толгой мал, өөрийн аймгийн бусад сумын нутагт 10 сумын 315 өрхийн 172.3 мянган толгой мал отор нүүдэл хийж байна.

Дархан хотын Малын удмын сангийн үндэсний төвд зохион байгуулагдсан Бог малын зохиомол хээлтүүлгийн мал үржүүлгийн технологич бэлтгэх сургалтад 2 албан хаагч хамрагдан чадавхжлаа.

Эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа иргэн, аж ахуй нэгжийн болон сумдын хөдөө аж ахуйн тасагт ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн судалгааг тус тус нэгтгэн ХХААХҮ-ийн яаманд хүргүүлээ.

Хүнс, газар тариалан, үйлдвэр, худалдаа үйлчилгээний чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 6-р тогтоол, 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 1 дүгээр хуралдааны тэмдэглэлд тусгагдсан согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулж, санал, дүгнэлт, танилцуулгыг Засгийн газарт танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулах зорилгоор Бигэр сумд үйл ажиллагаа явуулж байгаа “Шимт Дээж” ХХК-нд хяналт шалгалт хийж, архины тусгай зөвшөөрлийг сунгах саналыг холбогдох мэргэжлийн байгууллагуудад хүргүүлээд байна.

Сум, аж ахуйн нэгж, үйлдвэрлэгч иргэдийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгох, сурталчилах, үйлдвэрлэх хэмжээг нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, ажлын байр бий болгох зорилгоор “Алтай түншлэл-2020” үзэсгэлэн худалдааг 17 дахь жилдээ зохион байгуулж, 4 аймгийн, 13 сумын 80 гаруй үйлдвэрлэгч оролцлоо. Үзэсгэлэнд оролцогчдын 16 төрлийн 30 бүтээгдэхүүн шалгарч шагнагдсан ба 70.0 сая төгрөгийн борлуулалт хийгдлээ.

Мөн Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Монголын хүнсчдийн холбоо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 15 дахь жилдээ зохион байгуулж байгаа “Намрын ногоон өдрүүд-2020” үзэсгэлэн худалдаа 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 21-ний өдрүүдэд зохион байгуулагдан, 3 аж ахуйн нэгж, 1 иргэн оролцож нийт 18.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.

Тайлант хугацаанд “Наяд натур” ХХК 150 толгой адуу, 589 толгой хонь, 3895 толгой ямаа, нийт 4634 толгой мал, “Алтай сүрлэг нуруу” ХХК 940 толгой ямаа тус тус худалдан авсан ба нийт 349.5 мянган толгой малыг борлуулаад байна.

Төсөл сонгон шалгаруулах дэд хороо хуралдаж жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас эхний ээлжинд хаягдал дахин боловсруулах, сав баглаа боодол үйлдвэрлэл, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, өвлийн хүлэмж, махны зоорийн чиглэлийн 5 аж ахуйн нэгжийн төслийг сонгон шалгаруулж, нийт 500.0 сая төгрөгийг олголоо . Цаашид эх үүсвэр бий болсон тохиолдолд санхүүжүүлэхээр 7 аж ахуйн нэгжийн төслийг сонгон шалгаруулж ЖДҮХСанд хүргүүлээ.

Тайлант хугацаанд 842,8 га-аас 2670 тн ургац хураан авч, ургац хураалтын ажил 56.0 хувьтай байна.

Мал эмнэлгийн чиглэлээр хийгдсэн ажил: Биокомбинат Улсын үйлдвэрийн газартай байгуулсан гэрээний дагуу вакцин биобэлдмэлийг хүлээн авч, сумдад хуваарийн дагуу хүргүүлээ.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэл:

Арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	МЭНС-д төлөвлөлт		МЭНС-д гүйцэтгэл
		Төлөвлөсөн	Хувь	хувь
Галзуу	110100	110100	100	91,0
Боом	69200	64826	100	85.19
Цусан халдвар	131400	131400/70000	100	96,4
Дуут	5000	5000/5000	100	67,2
ДХХ энтербактериоз	412000	412000/35000	100	95,7
Адууны сахуу	8120	8120	100	93,6
Сохор догол	101080	101080	100	99,9
Шөвөг яр	299500	300135	100	96,7
Аймгийн дүн	1136300	1081076	100	95.0

Паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 4675.7 мян.тол мал хамрагдахаас туулгалтад 1158.9 мянган мал, боловсруулалтад 252.1 мянган мал, угаалгад 1909.7 мянган мал, нийт 3320.7 мянган толгой малыг хамруулж, гүйцэтгэл 71,0 хувьтай байна.

Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх үйл ажиллагаанд 4675.7 мян.тол мал, амьтан хамруулахаар төлөвлөж, тайлант хугацаанд мал туулгалтад 1158.9 мянган толгой мал, нохойн туулгалтад 6.6, боловсруулалтад 252.1, гуурын боловсруулалтад 57.9, угаалгад 1909.7 мянган мал, нийт 3385.5 мянган толгой мал, амьтан хамрагдаж, төлөвлөгөөний биелэлт 72.3 хувьтай байна.

Мал эмнэлгийн нэгдсэн системийн Мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээний бичилтэд өдөр тутмын хяналтыг цахимаар хийж, нийт 923 гэрчилгээ бичигдэж, бусад аймаг сумруу гарсан 572, гаднаас ирсэн 161, аймаг дотроо 190 гэрчилгээ бичигдсэн.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн “Бруцеллёзын вакцинжуулалтыг зохион байгуулах тухай” А/182 тушаал, “Бруцеллёзын вакцинжуулалтыг ажлыг зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын А/429 дүгээр захирамжийн хүрээнд бруцеллёз өвчний вакцинжуулалтад тугал-15602, хурга 250088, ишиг-487824, нийт-753514 толгой төл малыг хамруулж, гүйцэтгэл 94.2 хувьтай байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс үзүүлсэн мал, амьтны эрүүл мэндийн үзлэгт 2450.2 мянган толгой мал хамруулж, 68.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Ховд аймагт 9 дүгээр сарын 11-ний өдрөөс 14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан сургалтад 5 албан хаагч, Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори болон Стандарт хэмжилзүйн үндэсний төвийн хамтран зохион байгуулсан Дотоод аудитын сургалтад 1 албан хаагч, нийт 6 албан хаагч сургалтад хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Мал эмнэлгийн лабораторид хийгдсэн ажил:Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторитой хийсэн гэрээний дагуу шүлхий, бог малын мялзан өвчний тандах шинжилгээг хийж холбогдох бичиг баримт, гэрээ дүгнэсэн акт, нэхэмжлэл, ажлын тайлан зэргийг хүргүүлж шинжилгээний ажил бүрэн дууссан болно.

Бруцеллёзын шинжилгээг 208 буур, 703 бух, 5323 хуц, 7325 ухна, нийт 13589 хээлтүүлэгч малд хийж, Баян-Уул, Жаргалан, Цогт сумдаас 5 хээлтүүлэгч эерэг урвалтай гарсныг Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторит баталгаажуулах шинжилгээ хийлгэхээр хүргүүллээ.

Жаргалан сумын Бүрэн, Тээл, Завхан гол багийн нутагт хонь олноор үхсэн дуудлагын дагуу аймгийн Мал эмнэлгийн газраас ажлын хэсэг гарч газар дээр нь үзлэг хийж, шинжилгээнд шаардлагатай дээж материал авч шинжилгээ хийхэд цусан халдварт өвчин оношлогдсон тул 4000 хонийг вакцинжуулаад байна.

Халиун, Бигэр, Жаргалан сумдаас ирүүлсэн эмгэгт материалд нян судлалын шинжилгээ хийхэд цусан халдварт хордлого 3, доторын халдварт хордлого 3 оношлогдож, тус өвчинтэй тэмцэх зааврын дагуу арга хэмжээ авах талаар сумдад шинжилгээний хариу хүргүүллээ.

Аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа цайны газрын 915 кг махны 17 дээж, 310 ширхэг өндөгний 3 дээжид мал эмнэлэг ариун цэврийн магадлан шинжилгээ хийж гэрчилгээ олголоо. Мөн год-400, ноос 120 ширхэгт боом өвчний шинжилгээ хийсэн

ТАВ. БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Газар эзэмшүүлэх гэрээг 2020 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 10 дугаар сарын 12-ны өдрүүдэд зохион байгуулж байна. Алтай хотын инженерийн байгууламж бүхий бүсэд газар эзэмшигчийн үүргээ биелүүлээгүй, эзэмшил газраа 2 ба түүнээс дээш жил ашиглаагүй 31 иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтын дагуу газар эзэмших эрхийг хүчингүй болгох шийдвэрийг гаргахаар бэлтгэл ажил хийгдэж байна. Үүнд: Захиргааны ерөнхий хуулийн хүрээнд сонсох ажиллагааг 2020 оны 09 дүгээр сарын 16, 17, 18-ны өдрүүдэд зохион байгуулж, байгууллагын page хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хүргэн ажиллалаа.

Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг 6 байршил газарт цахимаар зохион байгуулж, худалдаа үйлчилгээний зориулалттай 1 байршил бүхий газрын гэрээ байгуулсан. Газрын цахим биржийн системд 496 нэгж талбарын үнийн мэдээг оруулж, байршилтай холбох ажил хийгдэж байна.

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2015 оны А/105 дугаар тушаалаар батлагдсан “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх журам, заавар”-ын дагуу аймгийн 18 сумын 77 багийн 329 цэгт мониторингийн цэгийн судалгааны мэдээллийг боловсруулан, судалж, фото мониторингийн аргаар үнэлсэн ажлын тайлан, холбогдох мэдээллийг ГЗБГЗЗГ-т хүргүүллээ.

Газар эзэмшигч байгууллага, иргэнээс мэдээлэл авч, кадастрын зураг, хаягийн тодорхойлолтийг гарган газар эзэмшүүлэх захирамжийн хамт Газрын кадастрын мэдээллийн санд оруулан, газар эзэмших эрхийн улсын бүртгэлийн Э дугаар авахад “ХУР” системийг ашиглаж байна.

Барилга угсралтын ажлын чиглэлээр: Барилга хот байгуулалтын яаманд улсын болон орон нутаг, төсөл хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын ажилд ашиглах цемент, арматурын судалгааг, ГЗБГЗЗГ-т бүтээн байгуулалт, дэд бүтцийн талаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний судалгааг тус тус гаргаж хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын 2020 оны 09 сарын 08 өдрийн А/515 тоот захирамжийн дагуу “Аксу-Алтай”ХХК-ийн бетон зуурмагийн узель, хайрга, дайрга, Орон нутгийн судлах музейн барилгын бетон зуурмаг, Алтай хот доторх 310 м авто замын хайрга зэргээс тус тус сорьцын дээж авч ГХБХБГ-ын лабораторит шинжилж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 14 сумын 21 барилга угсралтын ажилд захиалагчийн техникийн хяналтыг гүйцэтгэн, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Мөн Дарив сумын спорт заалны барилга, Баян-Уул сумын 960 хүүхдийн сургуулийн барилгын ашиглалтад тус тус дүгнэлт гаргалаа.

ЗУРГАА. НИЙГМИЙН САЛБАР:

Эрүүл мэндийн чиглэлээр: Аймгийн Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2020 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр зохион байгуулж, зөвлөгөөнд Эрүүл мэндийн салбарын удирдлагууд, нийт 70 гаруй албан хаагч оролцож эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлуудаа хэлэлцэн, салбарын ажлаа дүгнэн, шилдгүүдээ тодрууллаа.

“Эрүүл ахуйн аян-2020” үндэсний аяны хүрээнд Коронвируст халдвар /COVID-19/-өөс урьдчилан сэргийлэх зорилгоор Дэлхийн зөн олон улсын байгууллагын санхүүжилтээр Ерөнхий боловсролын сургуулийн 1, 2 дугаар ангийн хүүхдэд “Цэвэр гар -цагаан алчуур” гар угаах сургалтыг зохион байгууллаа. Сургалтын үр дүнд бага ангийн 516 хүүхэд гараа зөв угааж хэвшээд байна.

НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын албанаас зохион байгуулж буй бүсийн тоног төхөөрөмжийн инженерийн 5 өдрийн сургалтыг зохион байгуулж, Архангай, Завхан, Баянхонгор, Говь-Алтай аймгийн инженерүүд хамрагдан, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

“Халдварт бус өвчнөөс сэргийлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд 2020 оны 9 дүгээр сарын 22-ны өдрөөс 25-ны өдрүүдэд алслагдсан Наран, Рашаант багийн иргэдэд явуулын амбулаторийн үзлэг зохион байгуулж, 297 хүнийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрууллаа. Үзлэгээр хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэгтэй 30, зүрх судасны өвчлөлтэй 20, бөөр, шээсний замын өвчлөлтэй 8, арьс харшлын өвчлөлтэй 12, мэдрэлийн системийн өвчтэй 17, үе мөчний өвчлөлтэй 14, дотоод шүүрлийн эмгэгтэй 2, амьсгалын замын өвчлөлтэй 17, нийт 120 иргэнээс өвчлөл илэрч эмчилгээ зөвлөн, дараагийн шатанд шилжүүллээ.

Тархвар судлалын 2020 оны 39 дэх долоо хоног буюу 09 дугаар сарын 28-ны байдлаар аймгийн хэмжээнд амбулаториар 2367 үзлэг хийснээс 91, яаралтай тусламжийн 181 дуудлага хүлээн авч үйлчилснээс 15, нийт 106 томуу томуу төст өвчин бүртгэгдлээ.Томуугаар өвчлөгсдийн 75.2% нь 4 хүртэлх насны хүүхэд эзэлж байна.

Боловсрол, соёл урлагын чиглэлээр:

Есөнбулаг сумд шинээр 10, 11 дүгээр цэцэрлэг ашиглалтад орж байгаатай холбогдуулан сургуулийн өмнөх боловсролын бакалаврын зэрэгтэй багш нараас мэргэжлийн шалгалт авах боловсон хүчний сонгон шалгаруулалтыг 9 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулж, шалгалтад орсон 36 багш 15 ажлын байранд эрх зүй, ур чадвар, мэргэжлийн шалгалт өглөөд байна.

Шинэ хичээлийн жилд аймгийн хэмжээнд 31 цэцэрлэгт 3700 гаруй хүүхэд хамрагдан суралцаж байгаа болно.

Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам, Америкт төгсөгчдийн холбоо, аймгийн Засаг даргын тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар хамтран 12 дугаар ангийн сурагчдад “Зөв сонголт-гэрэлт ирээдүй” мэргэжил сонгох зөвлөгөө, мэдээлэл өгөх уулзалтыг зохион байгуулж, 250 сурагч хамрагдлаа.

Аймгийн төвийн гадаад хэлний 26 багшид АНУ-д суралцах боломж, тэтгэлэлт хөтөлбөрийн сургалт зохион байгууллаа, мэдээлэл хүргэлээ.

Багш нарын мэргэжил дээшлүүлэх институтийн онлайн сургалтад сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, нийт 50 албан хаагч хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

БСШУЯ-нд холбогдох мэдээллийн судалгааг судлагдахуун бүрээр гаргаж, хүргүүллээ.

Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын чиглэлээр: Аймгийн хэмжээнд өндөр насны тэтгэвэр 8447 хүнд 3000.0 сая төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмж 36 хүнд 59.8 сая, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 27 хүнд 3.6 сая, оршуулгын тэтгэмж 9 хүнд 9.0 сая, ажилгүйдлийн тэтгэмж 31 хүнд 21.2 сая, нийт 8550 хүнд 3093.6 сая төгрөгийг олголоо.

Шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан өндөр насны тэтгэвэр 70, хөгжлийн бэрхшээлтэй иргэний 44, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 6, нийт 120 даатгуулагчийн тэтгэврийн баримт материалыг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Сайн дурын даатгалд 20 иргэн, Эрүүл мэндийн даатгалд 477 иргэнийг хамруулж, 26.4 сая төгрөг ЭМД-ын санд төвлөрүүллээ.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж, шинээр 20 хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоож, 4 хүн цуцлагдаж 110 хүнийх сунгагдлаа. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой лавлагааг 36 иргэнд гаргаж өглөө.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр: Тайлант хугацаанд нийт 984 ажил хайгч иргэн бүртгэлтэй байгаа бөгөөд 4 иргэнийг ажлын байранд зуучлан оруулж, нийт 54 иргэн шинээр ажлын байраар хангагдлаа.

Нийгмийн халамжийн сангаас халамжийн тэтгэвэр 1384 иргэнд 392.8 сая, нөхцөлт мөнгөн тэтгэмж 1118 иргэнд 97.7 сая, амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 958 иргэнд 100.3 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж 240 иргэнд 29.8 сая, жирэмсэн эхийн тэтгэмж 315 иргэнд 9.0 сая, цалинтай эхийн тэтгэмж 308 эхэд 11.6 сая, алдар цолтой ахмадын хөнгөлөлт 30 иргэнд 5.5 сая, нийт 4353 иргэнд 646.7 сая төгрөгийг олголоо.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр: НҮБ-ын Хүүхдийн сан, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хамтарсан баг тус аймагт 09 дүгээр сарын 17,18-ны өдрүүдэд ажиллаж, “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцаж, сургалт зохион байгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

“Уур амьсгалын өөрчлөлт ба хүүхдийн эрх” цахим сургалтад хамрагдах нийт 58 багшийн мэдээллийг нэгтгэж, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын харьяа Сургалт, судалгаа, мэдээллийн төвд, сургалтын багц хэрэглэгдэхүүнийг тус аймгийн 26 сургуулийн багш нарт тус тус хүргүүлээ.

“Уур амьсгалын өөрчлөлт ба хүүхдийн эрх” уулзалт, хэлэлцүүлэг, сургалтыг 3 сургуульд зохион байгуулж, сурагчдын дунд 3 ЭКО клубийг байгуулан, үйл ажиллагаа явуулж байна.

Гэр бүлийн нандин харилцаа, үнэ цэнэ, хайрын түүхийн талаарх сайн туршлагыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Хайрын түүх” цуврал нэвтрүүлгийн эхний дугаарт залуу үеэ манлайлан ажиллаж, хөдөлмөрлөж байгаа Т.Бат-Эрдэнийн гэр бүлийг оролцуулан сайн туршлагыг түгээлээ.

АНУ-ын Элчин сайдын яамны олон нийттэй харилцах албаны дарга Роберт Тэйтээр ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн тус аймгийн Залуучуудын төлөөлөлтэй уулзаж, тэдний хөгжил оролцоо, тулгамдаж буй асуудал, АНУ-д суралцах боломжийн талаар мэдээлэл өгч, цаашид хамтран ажиллах талаар санал солилцлоо. Уулзалтын үр дүнд хувь хүний хөгжлийн болон хэлний мэдлэг олгох цахим сургалтыг зохион байгуулж, хамтран ажиллахаар шийдвэрлэлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс Халиун, Шарга, Тонхил, Дарви, Хөхморьт, Баян-Уул, Жаргалан, Тайшир, Гуулин, Дэлгэр сумдад ажиллаж нийт 283 хүүхдэд эмнэлгийн үзлэг хийж 123 хүүхдэд хөгжлийн бэрхшээл тогтоож, 111 хүүхдийн байнгын асаргааг сунгасан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхэд эмнэлэг, боловсролын үйлчилгээ болон хүүхэд хөгжүүлэх арга барил, дугуйлан секцэд хүүхдээ хамруулах талаар зөвлөгөө мэдээлэл өглөө.

ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Цогт сумд аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх зорлигоор Ээж хайрхан уулын энгэрт “Ээж шүтээн” хөшөөг байрлууллаа.

“Элсний нүүдэл-шийдэл” нээлттэй хаалганы өдөр, “Элсний фестиваль-2020” арга хэмжээг 2020 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр Хөхморьт сумд зохион байгуулж, Монгол элсний Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Газарзүй, гео-экологийн хүрээлэн, Монгол Улсын Их Сургуулийн багш, доктор н.Баярсайхан, доктор П.Бадарч болон орон нутгийн холбогдох албан тушаалтан, иргэд нийт 150 хүн оролцлоо.

Тус арга хэмжээнд “Элсний нүүлт, цөлжилтийн шалтгаан, үр дагавар, сургамж, өнөөгийн байдал, гарц шийдэл” сэдвээр судлаачид, эрдэмтдийн багийн хэлэлцүүлэг, “Элсний ач тус, үр өгөөжийг орон нутгийн иргэд, оролцогч талууд цаашид тогтвортой хүртэх боломж, гарц шийдлийг хэлэлцсэн арга хэмжээнүүд зохион байгуулагдан, элсний нүүлтийг сааруулах, цөлжилтөөс хамгаалах, ашигт ургамал ургах нөхцөлийг бүрдүүлэх талаар олон асуудлыг

хэлэлцэн тунхаг бичиг гаргаж, Монгол элсний үнэт зүйлс, түүний гайхамшгийг дотоодын аялагч, жуулчид, орон нутгийн иргэдэд сурталчилан танилцуулсан арга хэмжээ боллоо.

Мөн орчны байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн “Экологид ээлтэй бүтээгдэхүүн-2020” элсний гаралтай суль, цульхираар бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа иргэдийг дэмжих, иргэн, аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах зорилгоор үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, нөхөрлөлүүд эсгий урлал, хонины арьсан эдлэлээр хийсэн бүтээгдэхүүн, суль, цульхир, түүгээр хийсэн бүтээгдэхүүн, баялаг цай, цагаан идээ, сүү сүүн бүтээгдэхүүнээ сурталчиллаа.

Байгалийн нөөцийн хамтын менежмент нөхөрлөлүүдийн үзэсгэлэнгийн үеэр

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Нөхөн сэргээлт – 2020” арга хэмжээний хүрээнд 2020 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс 09-ний өдрүүдэд тус аймгийн 9 сумын нутаг дэвсгэрт ашигт малтмалын тусгай зөвшөөлийн дагуу хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн 2020 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт 50-70 хувьтай байгаа бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан, хийгдээгүй болон хийж дуусгах шаардлагатай ажлуудын хэрэгжилтийг ханган ажиллах, төлбөр тооцоог бүрэн барагдуулах талаар үүрэг чиглэлийг өглөө.

Хууль бусаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж орхигдсон 0,65 га, хайгуулын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж орхигдсон 0.82 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг тус тус хийгээд байна.

НАЙМ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Хүүхдийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтаар: Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Гуулин тосгон, Хөхморьт, Баян-Уул, Шарга, Жаргалан, Цээл сумдын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт төлөвлөгөөт хяналт шалгалт хийлээ. Мөн МХЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Есөнбулаг сумын 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9 дүгээр цэцэрлэгүүдээс хоолны 18 дээж, Дарив, Баянтоорой, Алтай, Есөнбулаг сумдын ерөнхий боловсролын 7 сургууль, Алтай, Есөнбулаг сумдын 11 цэцэрлэгээс хими, нян судлалын дээжийг тус тус авч шинжилгээнд өгч, лабораторид шинжлүүлэхээр хүлээлгэн өгснөөс гадна 18 сум, 2 тосгоны ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажилд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийлээ.

Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтаар: МХЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу ерөнхий боловсролын 23 сургууль, 27 цэцэрлэгийн багш, ажилчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байдалд хяналт шалгалт хийж,

дүгнэлт гаргасан ба онгоцоор зорчсон иргэдийн халуун хэмжилтийг тогтмол хийж, мэдээг МХЕГ-т хүргүүлэн ажиллалаа.

Хүнсний эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтаар:Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын даргын баталсан удирдамжийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч болон түүнийг дагалдан яваа ажлын хэсгийн бүрэлдэхүүн тус аймагт ажиллах болсонтой холбогдуулан 2020 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 23-ны өдрүүдэд “Ентүм” зоогийн газарт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж зоогонд орох хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хоолноос дээж авч МХГ-ын Нэгдсэн лабораторид шинжлүүлэн, улсын байцаагчийн дүнгэлт гарган ажиллалаа.

Хүнсний худалдааны 15 иргэн, аж ахуйн нэгжид гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, мэдээллийг шилэн хяналтын системд бүрэн оруулсан болно.

Байгаль орчны хяналтаар:Газрын хэвлийг дур мэдэн ашигласан 6 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 900.0 мянган төгрөгийн, ховор амьтны эд зүйл хууль бусаар худалдаалсан 1 иргэнд 300.0 мянган төгрөгийн, нийт 7 иргэнд 1200.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авлаа.

Газар, геодези зураг зүйн хяналтаар:Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 1 аж ахуйн нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 8 заалттай зөвлөмж хүргүүлсэн ба Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа 10 иргэн, аж ахуйн нэгжид урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж, 1 иргэнд 500.0 төгрөгийн шийтгэл ногдууллаа. Мөн тус аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийн дагуу шинжээчийн дүгнэлт гаргаж, иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 5 өргөдлийг шийдвэрлэлээ.

Геологи уул уурхайн хяналтаар: МХЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа 5 аж ахуйн нэгжид тандалт судалгаа хийж, танилцуулга саналыг МХЕГ-т хүргүүллээ.

Хэмжил зүйн хяналтаар: Батлагдсан удирдамжийн дагуу архи, дарсны 1 үйлдвэрт хяналт шалгалт хийж, танилцуулга, саналыг МХЕГ-т хүргүүллээ.

Мөн хэмжил зүйн чиглэлээр хийгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 8 заалт бүхий 1 албан шаардлагыг хүргүүлэн, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Харилцаа холбооны хяналтаар:Батлагдсан удирдамжийн дагуу 2 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 12 заалт бүхий 2 албан шаардлага хүргүүлэн, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

МХЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд 12 сум, 1 тосгонд барилга угсралт, засварын ажил гүйцэтгэж байгаа 13 аж ахуйн нэгж, мэдээлэл холбооны 20 м өндөр цамхагийн угсралтын ажил гүйцэтгэж байгаа 1 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд урьдчилан

сэргийлэх хяналт шалгалт хийж, 12 аж ахуйн нэгжид зөвлөмж хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Эрчим хүчний хяналтаар: МХЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд 12 сум, 1 тосгоны нам даралтын халаалтын зуух болон нэгдсэн халаалтын зуухны ашиглалтын үйл ажиллагаанд өвөлжилтын бэлтгэл ажлыг хэрхэн хангаж байгаа талаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 3 аж ахуйн нэгжид албан шаардлага, 6 аж ахуйн нэгжид зөвлөмж хүргүүлэн, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Барилгын техникийн хяналтаар: МХЕГ-аас барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч тус аймагт ажиллан, 5 сумын 6 байгууллагын барилгын ашиглалт, 7 аж ахуйн нэгжийн барьж байгаа барилга угсралтын ажилд хяналт шалгалт хийж байна.

Авто замын хяналтаар: МХЕГ-ын даргын баталсан удирамжийн дагуу Алтай хотын төвд баригдаж байгаа 2 км хатуу хучилттай авто замын угсралт, 320м цемент бетон замын угсралтын ажлын чанарт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 4 заалт бүхий албан шаардлага хүргүүлэн, биелэлтийг хангуулан ажиллаж байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтаар: Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд 17 сум, 2 тосгонд барилга угсралт, засварын ажил гүйцэтгэж байгаа 25 аж ахуйн нэгж, шинээр үйл ажиллагаа явуулж байгаа 23 аж ахуй нэгжид урьдчилан сэргийлэх шалгалтыг тус тус хийж, нийгмийн хамгаалал хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлээр 60 заалт бүхий зөвлөмж, 123 заалт бүхий 4 албан шаардлага хүргүүлж, 2 аж ахуйн нэгжид 3.0 сая төгрөгийн цалингийн зөрүү олгуулах улсын байцаагчийн акт тогтоож, 2 хуулийн этгээдэд 3.0 сая төгрөгийн шийтгэл ногдуулаад байна.

Төлөвлөгөөт хяналт шалгалтыг нийгмийн хамгаалал, хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр 3 аж ахуйн нэгжид хийж, 86 заалт бүхий 3 албан шаардлага хүргүүлэн, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Иргэнээс ирүүлсэн өргөдлийн дагуу 1 төлөвлөгөөт бус шалгалт хийж, 42.0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт үйлдэж, хариуг албан бичгээр хүргүүллээ. Мөн 1 аж ахуйн нэгжид гарсан үйлдвэрлэлийн ослын актыг хянан баталгаажууллаа.

МХЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд урьдчилан сэргийлэх шалгалтыг уул уурхай, барилга, дэд бүтцийн салбарын 17 аж ахуйн нэгжийг хамруулан шалгаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй орон тоонд төлөх төлбөрийг төлөөгүй 2 аж ахуйн нэгжид ногдох 20.3 сая төгрөгийн нөхөн төлбөрийг ногдуулан, улсын байцаагчийн 2 акт үйлдэж, танилцуулга болон хавсралт судалгааг гаргаж холбогдох газарт хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн авто замын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 1 байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл

ахуйн хуулийн хэрэгжилтийн байдалд улсын үзлэг зохион байгуулж, нэгдсэн тайлан судалгааг гаргалаа.

Цацрагийн хяналтаар: Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Алтай сум дахь “Эрдэнэдрилинг” ХХК-ийн өрөмдөж буй усны хайгуулын цооногийн геофизикийн судалгаанд үйл ажиллагаа явуулж буй “Монкаротаж” ХХК-д шалгалт хийж, 19 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд уул уурхайн салбарын объектуудад байгалийн гаралтай цацраг идэвхт изотопыг тодорхойлох тандалтыг 2 аж ахуй нэгжид хийж, 4 дээжийг цацрагийн хяналтын лабораторид хүргүүллээ.

Нэгдсэн лаборатори:Лабораторид 4 байгууллага, 13 аж ахуй нэгж, 12 иргэнээс ирүүлсэн хүнсний бүтээгдэхүүний 4 сорьцод 17 үзүүлэлт, ундны усны 5 сорьцод 36 үзүүлэлт, төмс хүнсний ногооны 71 сорьцод 184 үзүүлэлтээр нян судлал, хими хор судлал, хорио цээрийн шинжилгээ хийснээс ундны усны 1 сорьц 1 үзүүлэлтээр /магнийн хатуулаг/ стандартын шаардлага хангаагүй, хүнсний ногооны 3 сорьцод шавж /2 сорьцод манжингийн ялааны авгалдай, сонгины ялааны авгалдай/ илэрсэн учир ундны усны чанарыг сайжруулах тухай улсын байцаагчийн зөвлөмж болон хүнсний ногооны гарал үүслийн гэрчилгээг үндэслэн анх худалдан авсан газар(Ховд аймгийн)-улсын байцаагчид мэдээлэл хүргүүлсэн бөгөөд шавж илэрсэн хүнсний ногоог устгалд оруулсан болно. Төрийн тусгайгийн хоол, ундны ус, хүнсний бүтээгдэхүүний, нийт 28 сорьцод 57 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд стандартын шаардлага хангаагүй сорьц илрээгүй. Шинжилгээний төлбөр 184.6 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүллээ.

Бургастайн хилийн Экспорт, импорт хил хорио цээрийн талаар: Бургастайн хилийн боомтоор 436 тээврийн хэрэгсэл, 436 зорчигч гарч, орсон ба 28765 тн хүдрийн баяжмал экспортлогдлоо.

ЕС. СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ОНЦЛОГ АЖИЛ:

Есөнбулаг сум: Аяны богц арга хэмжээг 10 багийн малчдаар аялуулж эхлээд байна.

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/602 дугаар тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 58 дугаар тогтоолын дагуу ой цэвэрлэх ажлыг 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 09 дүгээр сарын 23-ны өдрүүдэд зохион байгуулж, 7 га газраас 112 м3 түлээний мод бэлтгэж, 425.000 төгрөгийг төсөвт төвлөрүүллээ.

Баян-Уул сум: Онцгой нөхцлийн үед Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан багш, ажиллагсдын ажил үүргийн хуваарь гаргаж, анги танхимуудын ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг тогтмол хийхийн зэрэгцээ хичээлийн байранд түр тусгаарлах өрөөг бэлтгэсэн.

Номын сангийн цахим хаягаар зохиолчдын өгүүллэгүүдийг толилуульж, уншигчдын хүртээл болгож байна.

Бигэр сум: 2020 оны хаваржилт хүндэрсэн, зун ган болсон тул малчид отор нүүдлээр Ховд, Баян-Өлгий, Дорнод, Увс аймаг болон өөрийн аймгийн Баян-Уул, Хөхморьт, Дарив сумдад нүүж отор нүүдэл хийж байгаатай холбогдуулан сумдын удирдлагуудтай холбогдон отроор явж байгаа малчдад төрийн үйлчилгээг тасралтгүй хүргэх талаар хэлэлцээр хийж байна. Тус сумаас отроор 80 гаруй өрхийн 30.0 мянга гаруй мал өөр аймаг, сумын болон өөрийн аймгийн бусад сумдад отор нүүдлээр явж байна.

Бугат сум: Аймгийн Засаг даргын 1/1321 дугаар шийдвэрийн дагуу Тахийн талд байгуулагдсан нисэх онгоцын хөөрч буух зурвасын хамгаалалтын бүсийг тогтоох тухай А/55 сумын Засагш даргын захирамж гарган шийдвэрлэлээ.

Корона вирусийн онцгой нөхцөл байдлын үед тус хичээлийн жил эхэлж байгаатай холбогдуулан 2020 оны 9 сарын эхний долоо хоногт багш ажилчид сурагчдаас тусгайлан батлагдсан зааврын дагуу асуумж судалгааг авч, ажиглалт тандалт хийсэн ба сургуулийн бүх багш ажилчдыг аймгийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн шинжлэгээнд бүрэн хамруулсан байна. Тусгаарлах өрөөг бэлтгэж, ариутгал халдваргүйжилт хийсэн.

Цээл: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж, хэв журмыг хангуулах чиглэлээр, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль тогтоомжоор хэсэгчилсэн тайлбар, сургалт мэдээллийг 6-12 дугаар ангийн 223 сурагчдыг хамруулан, зохион байгууллаа.

Ахлах бүлгийн 20 хүүхэд болон тэдний эцэг эх, нийт 40 хүнд эсгий урлалын сургалт зохион байгуулж, эсгийгээр улавч урлан, хүүхдийн эрүүл мэндийг дэмжин ажиллалаа.

Шарга сум: Тус сум нь аймгийн тусгай хэрэгцээний газар болох 1800 га хадлангийн талбайтай бөгөөд Хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд хадлангийн механикжсан 3 салаа ажиллаж, 31 нуруу буюу 620 тн, иргэд 174 тн, нийт 794 тн өвс бэлтгэснээс сумын аюулгүйн нөөцөд 100 тн өвсийг нөөцөллөө.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Өрмөн шаргал говь-2020” үзэсгэлэн худалдааг гар урлал, цагаан идээ, хүнсний ногоо гэсэн 3 төрлөөр зохион байгуулж, шилдгүүдээ шалгаруулан шагналаа.

Эрдэнэ сум: 4 багт нарны өргүүртэй худаг гаргах судалгаа, тооцоог хийж KFW төслийн байгууллагад хүргүүлээд байна. Тус сумын 12 малчин өрх отроор өөр аймгийн болон өөрийн аймгийн бусад сумд нутаглаж байна.

Номын баярыг зохион байгуулж шинэ ном, сурагчдын заавал унших номын үзэсгэлэн гарган, 47 иргэнд үйлчилж, гарын үсгийг монгол бичгээр бичүүлж үлдээсэн.